



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 11 өдөр

Дугаар 565

Улаанбаатар хот

Зээлийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, 62.1.16 дахь заалт, Сангийн яамны 2018 оны 8-3/7468 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Боинг 767-300ER” агаарын хөлгийн гадаад зээлийн эх үүсвэр бүхий Засгийн газрын баталгаат өрийн бичгийг дахин санхүүжүүлэх зориулалтаар 20.0 сая хүртэлх ам.долларын урт хугацаатай, хүү багатай, эд хөрөнгө барьцаалахгүй, компанийн үйл ажиллагааны орлогоос эргэн төлөх үндсэн нөхцөлтэй зээлийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих журмын дагуу дотоодын банкнаас авах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхийг “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (Р.Мэргэн)-д зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ГАНБАТ

Б.ГАВАА

000255